



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

Г “Жол” ХК-ийн үнэт цаасыг 7
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жол” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 79,545/далан есөн мянга таван зуун дөчин тав/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “МХБ” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТГХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн тухай болон уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдэгдлийг энэхүү тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх, уг мэдээлэлд эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг тусгахыг “Жол” ХК/Б.Көксеген/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.

4. Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг нэгж хувьцаанд 7027/долоон мянга хорин долоо/ төгрөгөөр тооцон “ҮЦТТГХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийг шаардах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангахыг “Жол” ХК/Б.Көксеген/-д үүрэг болгосугай.

5. “Жол” ХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ҮЦТТХТ” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай:

1/ Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авах

шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг хувьцаа эзэмшигчид шуурхай олгож ажиллах,

2/ ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хадгаламж дахь дансанд байршуулахдаа энэхүү тогтоолын 3-т заасан эрх тухайн дансны эзэнд үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрт зохих тайлбарыг өгч ажиллах,

3/ энэхүү тогтоолын 3-т заасан хүсэлтийг хувьцаа эзэмшигч гаргасан тохиолдолд

компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн хадгаламжийн байгууллага дахь дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг компанид буцаан шилжүүлэх.

6. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт тогтоолыг хүргүүлэхийн хамт компанийн эзэмшилд шилжин бүртгэх хувьцааны тооны талаар мэдэгдэж, тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН